



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/273

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Номин реалтор" ХХК (РД:5638771)-д аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/194 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 3 дахь заалтаар Мөрөн сум 6 дугаар баг Од-2, 202 дугаарт байршилтай 6712013335 нэгж талбарын дугаартай 145м<sup>2</sup> худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 40 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/194 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд "Номин реалтор" ХХК (РД:5638771)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР



Захирамж-2023

6712010343